



2026 оны 8 дугаар сарын 12-ны өдөр



**НИЙГМИЙН БОЛОН СУУРЬ ДЭД БҮТЦИЙН ТУЛГАМДАЖ БУЙ
АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ
Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага**

Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод “Эдийн засгийн тогтвортой өсөлт иргэн бүрдээ хүрсэн, дундаж давхарга зонхилсон, ядуурал эрс буурсан, эдийн засгийн хөгжлийн бодлогын суурийг бүрдүүлж, дотоод хэрэгцээгээ өөрсдөө хангадаг, экспорт эрчимжсэн, хөрөнгө оруулалт, хуримтлалын чадавхаа бүрдүүлсэн, олон тулгуурт эдийн засагтай улс болно” гэсэн зорилгыг дэвшүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.2 дахь хэсэгт “Монгол Улсын Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газар энэ хуулийн 36.1-д зааснаас бусад асуудлаар хууль тогтоомжийн төсөл санаачилж болно” гэж, Хууль тогтоомжийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5 дахь хэсэгт “Энэ хуулийн 14.4-т заасны дагуу хэд хэдэн хуулийн төслийг багцлан боловсруулахдаа тухайн харилцааг зохицуулж байгаа ерөнхий хуулийг дагаж анхдагч хуулийн төсөл боловсруулах, шинэчлэн найруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд төсөл тус бүрийн агуулгыг нэгтгэн нэг үзэл баримтлалаар тодорхойлж болно” гэж тус тус заасан нь Нийгмийн болон суурь дэд бүтцийн тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх тухай хуулийн төслийг боловсруулах хууль зүйн үндэслэл болж байна.

Практик шаардлага

Нэгдүгээрт, Монгол Улсын Үндсэн хуульд тунхагласан хүний эрх, эрх чөлөө, эдийн засгийн эрх чөлөөг хангах, Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжих, шударга өрсөлдөөнийг хамгаалах, технологи, инновацыг хөгжүүлэх, төрийн оролцоог зохистой түвшинд хязгаарлах, өсөлтийн үр өгөөжийг иргэдэд бодитоор хүртээх зорилгоор “Чөлөөлье” үндэсний санаачилгыг

Монгол Улсын Засгийн газраас дэвшүүлж, энэ хүрээнд 2026 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 285 дугаар тогтоолоор "Чөлөөлье" үндэсний санаачилгыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж эхлээд байна.

Энэхүү төлөвлөгөө нь (I) эдийн засгийн чөлөөлөлт, (II) ногоон чөлөөлөлт, (III) авлигын эсрэг чөлөөлөлт, (IV) эрх зүйн чөлөөлөлт гэсэн үндсэн дөрвөн багц арга хэмжээг багтаасан ба Эрчим хүчний шинэ эх үүсвэр, тархмал сүлжээ, хуримтлуурын шийдлийг дэмжихтэй холбогдсон арга хэмжээг ногоон чөлөөлөлтийн хүрээнд хэрэгжүүлэх бол эрх зүйн чөлөөлөлт арга хэмжээний хүрээнд хөрөнгө оруулалтын орчныг сайжруулж, хөрөнгө оруулалтын урсгалыг нэмэгдүүлэхээр тус тус төлөвлөөд байна.

Хоёрдугаарт, Монгол Улсын Засгийн газраас дэвшүүлсэн "Чөлөөлье" санаачилгын хүрээнд уул уурхайн олборлолт, ашигт малтмалын боловсруулах салбар дахь төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн эзэмшилд ногдох ногдол ашгийн орлогоос Үндэсний баялгийн сан болон улсын төсөвт ногдол ашгийн орлого хэлбэрээр төвлөрүүлэх, мөн зарим томоохон төсөл, хөтөлбөрүүдийг эрчимжүүлэх зарчмыг баримтлан ажиллаж байна.

Тухайлбал, "Чөлөөлье" санаачилгын төлөвлөгөөнд тусгагдсан гангийн цогцолбор, нүүрс-пиролизын үйлдвэр, зэс боловсруулах үйлдвэрийн цогцолбор барих болон газрын тос боловсруулах үйлдвэр барих төслүүдийг эрчимжүүлэхээс гадна Тавантолгойн 450 МВт-ын хүчин чадалтай дулааны цахилгаан станц барих, Зөөвч-Овоо төслийн бүтээн байгуулалтын үйл ажиллагааг эхлүүлэх болон Хэрлэн-Тооно гадаргын усыг хуримтлуулан ашиглах, Хойд бүргэд алтны үндсэн ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах, Асгатын мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах төслүүдийн үйл ажиллагааг эхлүүлж, шаардлагатай хөрөнгө оруулалт татах, төслийн хэрэгжилтийн явцад мэргэжлийн удирдлагаар хангах ажлыг "Чингис хаан баялгийн сан нэгдэл" ХХК хариуцан зохион байгуулж байна.

Дээр дурдсан арга хэмжээг хэрэгжүүлснээр төрийн өмчит компаниудын засаглал сайжрах нөхцөл бүрдэх ба мөн томоохон төслүүдийг эдийн засгийн эргэлтэд оруулснаар "Чингис хаан баялгийн сан нэгдэл" ХХК-ийн үндсэн үйл ажиллагааны орлого нэмэгдэх, цаашлаад Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь заалтад заасан "орлого төвлөрүүлэгч хуулийн этгээд"-ийн хувьд Үндэсний баялгийн санд төвлөрүүлэх орлогын хэмжээ бодитойгоор нэмэгдэх ач холбогдолтой.

Мөн Монгол Улсын Засгийн газрын "Чөлөөлье" үндэсний санаачилгын төлөвлөгөөнд тусгагдсан 'эрх зүйн чөлөөлөлт'-ийн дагуу хийгдэж буй арга хэмжээний хүрээнд Эдийн засгийн эрх чөлөөний тухай хууль, Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль зэрэг цогц хуулиуд хэрэгжиж эхэлснээр гадаадын шууд хөрөнгө оруулалт нэмэгдэх, ашигт малтмалын эрэлт, хайгуул эрчимжих, эрдэс баялгийн экспорт өсөх төлөвтэй байна.

Гуравдугаарт, "Оюу толгой" төслийн Хувь нийлүүлэгчдийн гэрээнд хувь нийлүүлэгчдийн зээлийн хүүгийн зохистой байдлыг 7 жил тутам хянан үзэхээр

заасан. Гэрээнд заасан уг эрхийг хэрэгжүүлэх хүрээнд төслийн хөрөнгө оруулагч талтай хэлэлцээг 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдөр албан ёсоор эхлүүлсэн болно.

Хэлэлцээний хүрээнд хувь нийлүүлэгчдийн зээлийн хүүгийн эрсдэлийн нэмэгдлийг анх тогтооход харгалзан үзсэн Монгол Улсын эрсдэл, зэсийн салбарын зах зээлийн нөхцөл, түүнчлэн Оюу толгой төслийн хэрэгжилт, санхүүгийн чадавх, ирээдүйн мөнгөн урсгалын төлөв зэрэг улсын, салбарын болон төслийн суурь нөхцөлүүд үндсэндээ өөрчлөгдөж, эрсдэлийн бодит түвшин мэдэгдэхүйц буурсан, мөн төслийн одоогийн санхүүжилтийн бүтэц болон гуравдагч этгээдийн зээлийн нөхцөлийг харгалзан талууд 2026 оны 06 дугаар сарын 30-ны өдөр хувь нийлүүлэгчдийн зээлийн хүү SOFR+6.5 хувь байсныг SOFR+4.0 хувь болгон бууруулахаар, мөн зээлийн зохистой байдлыг хянан үзэх 7 жилийн хугацааг 3 жил болгон богиносгохоор харилцан тохиролцсон болно.

Түүнчлэн, хэлэлцээний үр дүнд ногдол ашиг хуваарилах хугацааг наашлуулах, хувьцаа эзэмшигч талууд төслөөс бодит өгөөж хүртэх нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр харилцан тохиролцож, ногдол ашиг хуваарилах нөхцөл, аргачлалыг төслийн хөрөнгө оруулагч талтай 2026 онд үргэлжлүүлэн хэлэлцэж, эцэслэн тохиролцохоор болсон. Энэ хүрээнд Монгол Улсад төслөөс ногдох нийт өгөөжийг 53 хувьд хүргэх нөхцөлийг бүрдүүлэх, Монгол Улсад ногдох бодит өгөөжийг нэмэгдүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлж байна.

Оюу Толгой төслөөс 2027 онд Монгол Улсын Засгийн газрын буюу төрийн эзэмшилд ногдох ногдол ашгийн орлогоос 3,000.0 тэрбум төгрөг төсөвт төвлөрөхөөр тооцоолж байгаа бөгөөд үүнээс 2,000.0 тэрбум төгрөгийг нийгмийн өмнө тулгамдсан суурь асуудлууд болон эрчим хүч, бусад дэд бүтцийн салбарын санхүүгийн хүндрэлийг үе шаттай арилгах, хэвийн үйл ажиллагааг хангахад шаардлагатай хөрөнгийн дутагдлыг шийдвэрлэхээр тооцоолж байна.

Тухайлбал, Монгол Улсын 2027 оны төсвийн жилд уг төслийн үйл ажиллагаанаас Монгол Улсын Засгийн газарт буюу төрд ногдох ногдол ашгийн орлого нэмэгдсэнээр нэн тэргүүнд эрчим хүчний салбарт тулгамдсан асуудлыг шийдвэрлэж, өртөг зардлыг бууруулах, үйлчилгээний чанарыг сайжруулж ухаалаг тоолуурын системийг нэвтрүүлэх, дулааны хэрэглээнд суурилсан төлбөрийн тогтолцоог бий болгох, төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх боломж бүрдэнэ.

Улмаар эрчим хүчний салбарт хөрөнгө оруулснаар эрчим хүчний өсөн нэмэгдэж буй хэрэглээг тасралтгүй хангах нөхцөлийг бүрдүүлэх боломжтой бөгөөд дулааны шинэчилсэн тарифыг мөрдөж эхлэх болон цахилгааны тарифыг индексжүүлэх асуудлыг шийдвэрлэх юм.

Мөн уг төслийн төрд ногдох ногдол ашгийн орлогоос дээрх байдлаар хуваарилаад үлдэх хэсгийг Үндэсний баялгийн сангийн төрөлжсөн сангийн нэг болох Хуримтлалын санд хуваарилахаар хуулийн төсөлд тусгалаа.

Ийнхүү Оюу Толгой төслийн төрийн эзэмшилд ногдох ногдол ашгийн орлогоос Үндэсний баялгийн санд төвлөрүүлснээр Монгол Улсын Үндсэн хуулийн Зургаадугаар зүйлийн 2 дахь хэсэгт газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд тэгш, шударга хүртээх үзэл санаа бодитоор хэрэгжих юм.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төсөл 6 зүйлтэй байх бөгөөд доор дурдсан агуулгатай байна. Үүнд:

Нэгдүгээр зүйлд “Оюутолгой” ХХК-ийн төрийн эзэмшилд ногдох ногдол ашгийн орлогын хуваарилалтын талаар;

Хоёрдугаар зүйлд “Оюутолгой” ХХК-ийн төрийн эзэмшилд ногдох ногдол ашгийн орлогын эх үүсвэрээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн талаар;

Гуравдугаар зүйлд “Оюутолгой” ХХК-ийн төрийн эзэмшилд ногдох ногдол ашгийн орлогын эх үүсвэрээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн зохион байгуулалтын талаар;

Дөрөвдүгээр зүйлд хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн санхүүжилтийн талаар;

Тавдугаар зүйлд “Оюутолгой” ХХК-ийн төрийн эзэмшилд ногдох ногдол ашгийн орлогоор санхүүжүүлэх зардлын талаар;

Зургаадугаар зүйлд хуулийг дагаж мөрдөх хугацааг тус тус тусгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар

Хуулийн төсөл батлагдсанаар “Оюутолгой” ХХК-ийн төрийн эзэмшилд ногдох ногдол ашгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлж нэн шаардлагатай төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх эх үүсвэр бүрдэх ба түүнчлэн Үндэсний баялгийн санд ногдол ашгийн орлогоос төвлөрүүлж сангийн хуримтлалыг нэмэгдүүлэх, ингэснээр Үндэсний баялгийн сангаар дамжуулан байгалийн баялгийг хуваарилах Үндсэн хуулийн суурь зарчим хангагдана.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн төслийн талаар

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль тогтоомжид бүрэн нийцнэ. Хуулийн төсөлтэй холбогдуулан шинээр боловсруулах, шинэчлэн

найруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл
байхгүй болно.